



БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 13 өдөр

Дугаар А/42

Улаанбаатар хот

Өвөлжилт хүндэрсэнтэй холбоотойгоор
авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1, 77 дугаар зүйлийн 77.1 дэх хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсэг, 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.7, 32.1.8 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.2 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Засгийн газрын 2024 оны 02, 62 дугаар тогтоол, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтын 2.1.1 дэх заалт, Нийслэлийн Засаг даргын 2024 оны А/188 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дүүргийн хэмжээнд хаваржилт хүндэрч гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан малчин болон мал бүхий иргэдэд өвс худалдан авч тараах ажлыг зохион байгуулж ажиллахыг Засаг даргын Тамгын газар (Л.Санжийжамц), Онцгой байдлын хэлтэс (хурандаа Б.Цогбадрах) нарт үүрэг болгосугай.

2. Өвс худалдан авах ажлыг зохион байгуулахад шаардагдах 20,000,000 (Хорин сая) төгрөгийг Засаг даргын Тамгын газрын нэмэлт данснаас зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын Ерөнхий нягтлан бодогч (С.Баасанхүү)-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Засаг даргын Эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч (Б.Болормаа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА




А.СҮХБОЛД

АЖИЛ 2024 он ажил/захирамж

1123200067

Нийслэлийн Багахангай дүүргийн Засаг даргын
2024 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн 112 дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт



ШААРДАГДАХ ЗАРДЛЫН ТӨСӨВ

№	Материалын нэр	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ	Шаардагдах хэмжээ	Бүгд үнэ
1.	Өвс	Боодол	28,500	700	19,950,000
2.	Өвс	Боодол	25,000	2	50,000
Нийт					20,000,000